



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Эзэмшиж буй газрын байршил,
зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/40 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байршил зориулалт өөрчлүүлэхээр хүсэлт гаргасан 1 (нэг) аж ахуйн нэгжийн газрын байршил, зориулалтыг хавсралтад зааснаар өөрчилсүгэй.

2. Газрын байршил, зориулалт өөрчлүүлж буй аж ахуйн нэгжтэй холбогдох хууль тогтоомж, эрхийн актын дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/12 дугаар захирамжийн “Зундуй экспл” ХХК-д хамаарах заалтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 03 сарын 27-ны өдрийн А.У. дугаар
захирамжийн хавсралт

ЭЗЭМШИЖ БУЙ ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ ӨӨРЧИЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Газар эзэмшигч ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагын		Газрын							Өмнө нь гарсан ДЗД-ын захирамж шийдвэр
	Хуулийн этгээд	Регистр	Байршил	Зориулалт	Хэмжээ м2	Хугацаа (жил)	Эдэл бэрийн хэлбэр	Өмнөх байршил	Өмнөх зориулалт	
1	Зундуй экспл" ХХК	6205917	БХД 2-р хороо Мастермайнинг ХХК-ны хойд талд	Үйлдвэрлэл	20000	15	Эзэмших	1-р хороо Хээхрийн хоолой	Төмс хүнсний ногоо тариалах	2023 оны А/12